БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймгийн Баян-Өндөр сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код: БНА-2022/142/НА-СТА-ТШЗ**


Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат

Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn

Аудитын менежер: А.Цээням

Утас: 99442140 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Азбаяр

Утас: 99061429 Цахим хаяг: azbayarb@audit.gov.mn

Цахим хуудас: www.audit.mn


Баянхонгор
2022 он

## Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ..... 4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан /төгрөгөөр/ ..... 4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан /төгрөгөөр/ ..... 5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан /төгрөгөөр/ ..... 6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан /төгрөгөөр/ ..... 8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /төгрөгөөр/ ..... 9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан /төгрөгөөр/ ..... 10
3. Аудитын тайлан ..... 11
3.1 Ерөнхий зүйл ..... 11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт ..... 11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ..... 12
3.4 Материаллаг байдал ..... 12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга ..... 12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ..... 13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг ..... 14
3.8 Аудитын гол асуудал ..... 14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ..... 14
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт ..... 14
3.9.2 Засгийн "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын хэрэгжилт ..... 15
3.9.3 Бусад хууль тогтоомжийн хүрээнд ..... 15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ..... 15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал ..... 15
4. Аудитын илрүүлэлт ..... 15
4.1. Албан шаардлага ..... 15
4.2 Зөвлөмж ..... 16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл ..... 16

### Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584
E-mail; bayankhongor@audit.gov.mn

2022. 02. 16 № 2/13

танай _____ -ны № _____ -т

БАЯНХОНГОР АЙМГИЙН БАЯН-ӨНДӨР
СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
Б.САМДАНЖИГМЭД ТАНАА

# АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Баян-Өндөр сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө,өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн Баян-Өндөр сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Б.МӨНХБАТ

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан /төгрөгөөр/ 2021.12.31

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **97,937,802.00** | **103,880,272.00** |
| **33** | **АВЛАГА** | 9,950,000.00 | 3,823,000.00 |
| **335** | **Бусад авлага** | 9,950,000.00 | 3,823,000.00 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 9,950,000.00 | 3,823,000.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 87,987,802.00 | 100,057,272.00 |
| **351** | **Түүхий эд материал** | 712,650.00 | 1,642,700.00 |
| 35130 | Эм боох материал | 712,650.00 | 1,642,700.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 87,275,152.00 | 98,414,572.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 1,692,380.00 | 1,974,730.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 4,666,500.00 | 4,204,350.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 5,876,300.00 | 6,883,800.00 |
| 35460 | Хүнсний материал | 366,420.00 | 2,003,490.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 74,673,552.00 | 83,348,202.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,429,050,628.89** | **1,375,489,250.23** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 1,429,050,628.89 | 1,375,489,250.23 |
| **392** | **Биет хөрөнгө** | 1,412,454,628.89 | 1,358,893,250.23 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,464,064,429.64 | 1,464,064,429.64 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -137,269,170.31 | -207,616,794.43 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 124,006,817.00 | 158,679,167.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -92,429,968.24 | -106,156,810.89 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 72,022,450.00 | 73,383,850.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -44,054,068.60 | -49,033,763.85 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 11,630,248.00 | 11,630,248.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -9,770,075.60 | -10,832,942.24 |
| 39217 | Ном | 24,253,967.00 | 24,775,867.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 16,596,000.00 | 16,596,000.00 |
| 39301 | Програм хангамж | 300,000.00 | 300,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -300,000.00 | -300,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 16,596,000.00 | 16,596,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1,526,988,430.89** | **1,479,369,522.23** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **00.00** | **141,400.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 00.00 | 141,400.00 |
| **413** | **Өглөг** | 00.00 | 141,400.00 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 00.00 | 141,400.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,526,988,430.89** | **1,479,228,122.23** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 1,526,988,430.89 | 1,479,228,122.23 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 280,983,355.00 | 280,983,355.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 280,983,355.00 | 280,983,355.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 38,263,476.87 | -9,496,831.79 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 38,263,476.87 | 38,263,476.87 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | -47,760,308.66 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 1,207,741,599.02 | 1,207,741,599.02 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1,526,988,430.89** | **1,479,369,522.23** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан /төгрөгөөр/ 2021.12.31

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **841,219,812.00** | **898,443,616.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **4,586,352.00** | **19,568,000.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 4,586,352.00 | 19,568,000.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 4,586,352.00 | 00.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,000,000.00 | 00.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 3,586,352.00 | 00.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **836,633,460.00** | **878,875,616.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **722,013,300.00** | **680,706,100.00** |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 722,013,300.00 | 680,706,100.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 22,224,460.00 | 101,400,665.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 12,674,960.00 | 88,535,165.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 9,549,500.00 | 12,865,500.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 92,395,700.00 | 96,768,851.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 92,395,700.00 | 96,768,851.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **875,525,680.14** | **946,203,924.66** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **875,525,680.14** | **946,203,924.66** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 823,716,497.14 | 816,130,391.66 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 531,005,349.00 | 525,380,319.00 |
| 210101 | Үндсэн цалин | 531,005,349.00 | 525,380,319.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 67,679,946.00 | 68,192,608.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 46,326,853.00 | 47,422,710.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,450,217.00 | 5,311,541.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,319,853.00 | 4,245,873.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,053,001.00 | 1,019,317.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 10,530,022.00 | 10,193,167.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 88,096,582.00 | 94,268,851.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,811,843.00 | 2,476,314.00 |
| 210302 | Түлш, халаалт | 86,044,739.00 | 91,552,537.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 240,000.00 | 240,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 13,053,120.00 | 9,794,590.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,397,570.00 | 1,311,830.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 5,173,400.00 | 1,798,240.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,259,700.00 | 1,380,720.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 117,900.00 | 60,600.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 483,950.00 | 438,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,739,200.00 | 4,805,200.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 1,881,400.00 | 00.00 |
| **2105** | **Норматив зардал** | 14,016,960.00 | 14,302,720.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 786,490.00 | 1,128,700.00 |
| 210502 | Хоол, хүнс | 13,230,470.00 | 12,874,020.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 00.00 | 300,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 11,342,700.00 | 3,079,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 11,342,700.00 | 3,079,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,949,000.00 | 446,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,949,000.00 | 446,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 2,068,700.00 | 7,144,875.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,618,700.00 | 6,644,875.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зөрэглэл тогтоох | 450,000.00 | 500,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 94,504,140.14 | 93,521,428.66 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,397,100.00 | 1,570,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 481,760.00 | 1,834,400.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 92,625,280.14 | 90,117,028.66 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 51,809,183.00 | 130,073,533.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 25,674,860.00 | 109,376,490.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 11,382,300.00 | 24,697,200.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 00.00 | 52,272,400.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 12,674,960.00 | 31,789,890.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,617,600.00 | 617,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 5,933,618.00 | 4,549,500.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,384,118.00 | 00.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 20,200,705.00 | 16,147,543.00 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 20,200,705.00 | 16,147,543.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **-34,305,868.14** | **-47,760,308.66** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **-34,305,868.14** | **-47,760,308.66** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан /төгрөгөөр/ 2021.12.31

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **837,633,460.00** | **878,875,616.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **1,000,000.00** | **00.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 1,000,000.00 | 00.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 1,000,000.00 | 00.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,000,000.00 | 00.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **836,633,460.00** | **878,875,616.00** |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 722,013,300.00 | 680,706,100.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 22,224,460.00 | 101,400,665.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 12,674,960.00 | 88,535,165.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 9,549,500.00 | 12,865,500.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 92,395,700.00 | 96,768,851.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсвөт байгууллага/ | 92,395,700.00 | 96,768,851.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **800,164,560.00** | **866,064,316.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **800,164,560.00** | **866,064,316.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **748,355,377.00** | **732,167,783.00** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 531,005,350.00 | 525,238,917.00 |
| 210101 | Үндсэн цалин | 377,181,749.94 | 389,358,401.00 |
| 210102 | Нэмэгдэл | 78,261,520.84 | 97,059,383.00 |
| 210104 | Урамшуулал | 75,562,079.22 | 38,821,133.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 67,679,945.00 | 68,192,610.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210201 | Тэтгэврийн даатгал | 46,647,160.00 | 50,603,310.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,338,209.00 | 4,338,400.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,246,906.00 | 3,470,000.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,040,787.00 | 1,008,600.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 10,406,883.00 | 8,772,300.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 88,096,582.00 | 94,268,851.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,811,843.00 | 2,476,314.00 |
| 210302 | Түлш, халаалт | 86,044,739.00 | 91,552,537.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 240,000.00 | 240,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 11,539,950.00 | 6,866,840.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,209,900.00 | 1,191,280.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 5,173,400.00 | 1,798,240.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,259,700.00 | 1,380,720.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 145,200.00 | 360,600.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 483,950.00 | 438,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,267,800.00 | 1,698,000.00 |
| **2105** | **Норматив зардал** | 13,667,990.00 | 17,514,340.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 1,805,140.00 | 1,266,050.00 |
| 210502 | Хоол, хүнс | 10,075,050.00 | 14,511,090.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,787,800.00 | 1,737,200.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 10,999,000.00 | 4,485,500.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 2,920,000.00 | 399,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 8,079,000.00 | 4,086,500.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,949,000.00 | 446,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,949,000.00 | 446,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 2,497,000.00 | 7,966,875.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,047,000.00 | 7,268,875.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 450,000.00 | 500,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 00.00 | 198,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 20,920,560.00 | 7,187,850.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,079,100.00 | 4,638,550.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 18,841,460.00 | 2,549,300.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **51,809,183.00** | **133,896,533.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 25,674,860.00 | 109,376,490.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 11,382,300.00 | 24,697,200.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 00.00 | 52,272,400.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 12,674,960.00 | 31,789,890.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,617,600.00 | 617,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 5,933,618.00 | 8,372,500.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,384,118.00 | 00.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 20,200,705.00 | 16,147,543.00 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 20,200,705.00 | 16,147,543.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **37,468,900.00** | **12,811,300.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **37,468,900.00** | **12,811,300.00** |

| | | | |
|---|---|---|---|
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **37,468,900.00** | **12,811,300.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 37,468,900.00 | 12,811,300.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 37,468,900.00 | 12,811,300.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-37,468,900.00** | **-12,811,300.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 00.00 | 00.00 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 00.00 | 00.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 00.00 | 00.00 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан /төгрөгөөр/ 2021.12.31

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 280,983,355.00 | 1,207,741,599.02 | 72,569,345.01 | 00.00 | 1,561,294,299.03 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **280,983,355.00** | **1,207,741,599.02** | **72,569,345.01** | **00.00** | 1,561,294,299.03 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -34,305,868.14 | 00.00 | -34,305,868.14 |
| C08 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **280,983,355.00** | **1,207,741,599.02** | **38,263,476.87** | **00.00** | 1,526,988,430.89 |
| D01 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **280,983,355.00** | **1,207,741,599.02** | **38,263,476.87** | **00.00** | 1,526,988,430.89 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **280,983,355.00** | **1,207,741,599.02** | **38,263,476.87** | **00.00** | 1,526,988,430.89 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -47,760,308.66 | 00.00 | -47,760,308.66 |
| D09 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **280,983,355.00** | **1,207,741,599.02** | **-9,496,831.79** | **00.00** | 1,479,228,122.23 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /төгрөгөөр/ 2021.12.31

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | Зөрүү | хувь |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | | |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 784,350,100.00 | 761,327,408.00 | (23,022,692.00) | 97.1 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 784,350,100.00 | 761,327,408.00 | (23,022,692.00) | 97.1 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 752,572,300.00 | 736,013,208.00 | (16,559,092.00) | 97.8 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 525,523,000.00 | 525,238,917.00 | (284,083.00) | 99.9 |
| 210101 | Үндсэн цалин | 424,961,100.00 | 389,358,401.00 | (35,602,699.00) | 91.6 |
| 210102 | Нэмэгдэл | 63,947,500.00 | 97,059,383.00 | 33,111,883.00 | 151.8 |
| 210104 | Урамшуулал | 36,614,400.00 | 38,821,133.00 | 2,206,733.00 | 106.0 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 68,337,700.00 | 68,192,610.00 | (145,090.00) | 99.8 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 50,681,500.00 | 50,603,310.00 | (78,190.00) | 99.8 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,414,100.00 | 4,338,400.00 | (75,700.00) | 98.3 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,531,200.00 | 3,470,000.00 | (61,200.00) | 98.3 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 882,800.00 | 1,008,600.00 | 125,800.00 | 114.3 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 8,828,100.00 | 8,772,300.00 | (55,800.00) | 99.4 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 101,144,000.00 | 94,268,851.00 | (6,875,149.00) | 93.2 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,025,500.00 | 2,476,314.00 | (1,549,186.00) | 61.5 |
| 210302 | Түлш, халаалт | 96,878,500.00 | 91,552,537.00 | (5,325,963.00) | 94.5 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 240,000.00 | 240,000.00 | - | 100.0 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 7,416,900.00 | 7,388,740.00 | (28,160.00) | 99.6 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,191,900.00 | 1,191,280.00 | (620.00) | 99.9 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,800,000.00 | 1,798,240.00 | (1,760.00) | 99.9 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,403,300.00 | 1,380,720.00 | (22,580.00) | 98.4 |
| 210404 | Ном, хэвлэл | 883,100.00 | 882,500.00 | (600.00) | 99.9 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 440,000.00 | 438,000.00 | (2,000.00) | 99.5 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,698,600.00 | 1,698,000.00 | (600.00) | 100.0 |
| **2105** | **Норматив зардал** | 26,606,100.00 | 17,514,340.00 | (9,091,760.00) | 65.8 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 1,293,600.00 | 1,266,050.00 | (27,550.00) | 97.9 |
| 210502 | Хоол, хүнс | 23,569,000.00 | 14,511,090.00 | (9,057,910.00) | 61.6 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,743,500.00 | 1,737,200.00 | (6,300.00) | 99.6 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 13,136,500.00 | 13,135,500.00 | (1,000.00) | 100.0 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 9,050,000.00 | 9,049,000.00 | (1,000.00) | 100.0 |
| 210604 | Урсгал засвар | 4,086,500.00 | 4,086,500.00 | - | 100.0 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 454,700.00 | 446,000.00 | (8,700.00) | 98.1 |
| 210702 | Дотоод албан томилолт | 454,700.00 | 446,000.00 | (8,700.00) | 98.1 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,367,500.00 | 1,279,000.00 | (88,500.00) | 93.5 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 627,500.00 | 581,000.00 | (46,500.00) | 92.6 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 500,000.00 | 500,000.00 | - | 100.0 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 240,000.00 | 198,000.00 | (42,000.00) | 82.5 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 8585900.00 | 8549250.00 | (36,650.00) | 99.6 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 6,000,000.00 | 5,999,950.00 | (50.00) | 100.0 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,585,900.00 | 2,549,300.00 | (36,600.00) | 98.6 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 31777800.00 | 25314200.00 | (6,463,600.00) | 79.7 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 31,777,800.00 | 25,314,200.00 | (6,463,600.00) | 79.7 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 31,157,200.00 | 24,697,200.00 | (6,460,000.00) | 79.3 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 620,600.00 | 617,000.00 | (3,600.00) | 99.4 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 784,350,100.00 | 761,327,408.00 | (23,022,692.00) | 97.1 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 680,706,100.00 | 664,558,557.00 | (16,147,543.00) | 97.6 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 680,706,100.00 | 664,558,557.00 | (16,147,543.00) | 97.6 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 103,644,000.00 | 96,768,851.00 | (6,875,149.00) | 93.4 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 103,644,000.00 | 96,768,851.00 | (6,875,149.00) | 93.4 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 47.00 | 46.00 | (1.00) | 97.9 |
| 620001 | Удирдах ажилтан | 01.00 | 01.00 | - | 100.0 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 33.00 | 32.00 | (1.00) | 97.0 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 13.00 | 13.00 | - | 100.0 |
| **63** | **СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)** | 437.00 | 402.00 | (35.00) | 92.0 |
| **630** | **ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД** | 437.00 | 402.00 | (35.00) | 92.0 |
| 630001 | Төрийн өмчит ЕБС | 437.00 | 402.00 | (35.00) | 92.0 |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **47.00** | **46.00** | (1.00) | 97.9 |
| 650004 | СЄБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД) | 33.00 | 32.00 | (1.00) | 97.0 |
| 650006 | Соёл урлагийн салбарын төрийн їйлчилгээний албан хаагч (ТҮСУ) | 01.00 | 01.00 | - | 100.0 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 13.00 | 13.00 | - | 100.0 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан /төгрөгөөр/ 2021.12.31

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **17,674,960.00** | **93,028,165.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **17,674,960.00** | **93,028,165.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **5,000,000.00** | 8,965,875.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 5,000,000.00 | 8,965,875.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 5,000,000.00 | 8,965,875.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 12,674,960.00 | 84062290.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 12,674,960.00 | 84,062,290.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | | 52,272,400.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 12,674,960.00 | 31,789,890.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 17,674,960.00 | 93,028,165.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 17,674,960.00 | 93,028,165.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 12,674,960.00 | 84,712,165.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 5,000,000.00 | 8,316,000.00 |
| **IV** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | **0.00** | **0.00** |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0.00 | 0.00 |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0.00 | 0.00 |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Баянхонгор аймгийн Баян-Өндөр сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Азбаяр гүйцэтгэж, чанарын хяналтыг ахлах аудитор М.Алтантуяа, аудитын менежер А.Цээням, Газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн Баян-Өндөр сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт төсвийн гүйцэтгэлийн аудит хийлгэх хүсэлтийг 2022 оны 01 дүгээр сарын 17-ний өдрийн 07 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

Баянхонгор аймгийн Баян-Өндөр сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны төсвийн хөрөнгийг захиран зарцуулах эрхийн 1 дүгээр гарын үсгийг Б.Самданжигмэд, 2 дугаар гарын үсгийг З.Саранчулуун нар зурсан байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Баянхонгор аймгийн Баян-Өндөр сумын ерөнхий боловсролын сургуулийн зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Сургалтын таатай орчин бүрдүүлсэн, чадвартай хөгжсөн багш ажилтантай, чанартай хүртээмжтэй сургалттай, стандартын шаардлагыг жигд хангасан, хүүхдэд ээлтэй сургууль болно.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Аймгийн Санхүү, хяналт аудитын алба нь дотоод аудитын ччг үүргийг хэрэгжүүлдэг ба Баянхонгор аймгийн Баян-Өндөр сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор аймгийн Баян-Өндөр сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл "Дунд" гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 875,525.7 мянган төгрөгөс 1.0 хувиар буюу 8,755.3 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 6,128.7 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад гүйцэтгэлийн үе шатанд хянаж үзэхэд 2021 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлаас тооцоход 6,612.4 мянган төгрөг байгаа тул шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Баянхонгор аймгийн Баян-Өндөр сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 47,618.9 мянган төгрөгөөр буюу 3.1 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| А | 1 | 2 | 3=2-1 |
| ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 97,937.8 | 103,880.3 | 5,942.5 |
| Мөнгөн хөрөнгө | - | - | - |
| Авлага | 9,950.0 | 3,823.0 | (6,127.0) |
| Урьдчилгаа | - | - | - |
| Бараа материал | 87,987.8 | 100,057.3 | 12,069.5 |
| ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 1,429,050.6 | 1,375,489.3 | (53,561.4) |
| Үндсэн хөрөнгө | 1,712,873.9 | 1,749,429.6 | 36,555.7 |
| Хуримтлагдсан элэгдэл | (283,823.3) | (373,940.3) | (90,117.0) |
| **Нийт хөрөнгө** | **1,526,988.4** | **1,479,369.5** | **(47,618.9)** |
| Өр төлбөр | - | 141.4 | 141.4 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 1,526,988.4 | 1,479,228.1 | (47,760.3) |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **1,526,988.4** | **1,479,369.5** | **(47,618.9)** |

Авлагын данс дансны үлдэгдэл 3,823.0 мянган төгрөг болж 6,127.0 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны эцэст ухаалаг самбарын мөнгийг шилжүүлэн 2021 онд тухайн

хөрөнгө ирсэн бол тайлант оны нэмэлт санхүүжилтийн дансны төвлөрүүлсэн үлдэгдлийг авлагаар бүртгэсэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 100,057.3 мянган төгрөг болж 12,069.5 мянган төгрөгөөр өссөн нь бусад хангамжийн материал 8,674.6 мянга, хүнсний материал 1637.1 мянга, барилгын засварын материал 1,007.5 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь голлох нөлөөг үзүүлсэн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,749,429.6 мянган төгрөг болж 36,555.7 мянган төгрөгөөр өссөн нь "Хонгорын тогтвортой хөгжил" НҮТББ-ийн төслөөр 12,794.4 мянга, "Эрдэнэ Монгол" ХХК-аас 1,000.0 мянган төгрөг төсвийн хөрөнгөөр 12811.3 мянган төгрөгөөр машин тоног төхөөрөмж, ном худалдан авсан нь голлох дүнг эзэлж байна. Тайлант онд хөрөнгө акталж, данснаас хасаагүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,479,228.1 мянган төгрөг болж 47,760.3 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгийн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,070,961.8 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1,070,961.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 361,392.8 мянган төгрөгөөр бууруулж 709,569.0 мянган төгрөгөөр анх батлагдсан байна. Санал хүргүүлсэн зардлаас цалингийн зардлыг 174,246,3 мянга, ЭМНДШ-ийг 14,288.5 мянга, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 8,464.3 мянга, норматив зардлыг 24,728.4 мянга, урсгал шилжүүлэг 117,281.1 мянган төгрөгөөр тус тус бууруулан батлагдсан байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр 784,350.1 мянган төгрөгийн төсөв баталсныг төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөснөөс 680,706,1 мянган төгрөгийг тусгай шилжүүлгээр, 103,644.0 мянган төгрөгийг орон нутгийн тогтмол зардлын санхүүжилтээр баталсан байна .

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 777,475.0 мянган төгрөгийн санхүүжилт авсан нь тогтмол зардлын санхүүжилт 6875.1 мянган төгрөгөөр дутуу санхүүжүүлсэнтэй холбоотой бөгөөд ирсэн санхүүжилтээс үйл ажиллагаанд 761,327.5 мянган төгрөгийг зарцуулж оны эцэст 16,147.5 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 761,327.5 мянган төгрөг буюу 97.1 хувьтай байгаа бөгөөд санхүүжилт 6875.1 мянган төгрөгөөр дутуу санхүүжигдсэн байна. Тайлант онд цалингийн зардал 284.1 мянга, ЭМНДШ-ийн зардал 145.1 мянга, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 6875.1 мянга, норматив зардал 9,091.8 мянга, урсгал шилжүүлэг 6,463.6 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэн нь гол нөлөө үзүүлж байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тухайн байгууллага нь 2021 онд нэмэлт санхүүжилтийн дансаар тэтгэвэр гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжээр 52,272.4 мянга, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан 5 жилийн тэтгэмж 31789.9 мянга, төслийн санхүүжилтээр 8,316.0 мянга, 2020 оны үлдэгдлээс 4,549.5 мянга, тэтгэлэгт хөтөлбөрийн санхүүжилтээр 4,300.0 мянган төгрөгийн санхүүжилт хүлээн авч зарцуулсан бөгөөд оны эцэст 3,823.0 мянган төгрөгийг төвлөрүүлж авлагаар тусгасан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тус байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Цэрэнчимэд санхүүгийн тайлангийн аудит хийсэн бөгөөд тайлант оны санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх оны санхүүгийн тайлангийн мэдээллийг хамруулаагүй болно.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нийт 63 арга хэмжээ төлөвлөснөөс жилийн эцсийн байдлаар 83 хувьтай дүгнэгдсэн байна.

### 3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт зардал 946,203.9 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 70,678.2 мянган төгрөгөөр буюу 8.1 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлууд нь цалин, хөлс болон тэтгэмжийн зардал өмнөх оноос нэмэгдсэн байгаа бол бусад зардлууд нь өмнөх оноос буурсан үзүүлэлттэй байна.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн аудитын байгууллагаас шилэн дансны 2021-2022 оны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэх ерөнхий чиглэл"-ийн 1 дүгээр хавсралтад заасан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тайлант хугацаанд оруулбал зохих 1,064,899.0 мянган төгрөгийн үнийн дүнтэй 151 мэдээллээс, хугацаандаа оруулсан 891,126.8 мянган төгрөгийн 139 мэдээлэл, хугацаа хоцроож байршуулсан 173,772.2 мянган төгрөгийн 10 мэдээлэл, хугацаа болоогүй 2 мэдээлэл байна. Иймд цаашид мэдээллийг хугацаанд нь байршуулах зөвлөмж өгөв.

| д/д | Хугацаа | Төрөл | Удаа | Хугацаанд байршуулсан | Хугацаа хоцроож байршуулсан | Хугацаа болоогүй |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Бүтэн жил | 11 | 11 | 7 | 2 | 2 |
| 2 | Хагас жил | 4 | 4 | 4 | 0 | 0 |
| 3 | Улирал бүр | 1 | 4 | 3 | 1 | 0 |
| 4 | Сар бүр | 3 | 36 | 35 | 1 | 0 |
| 5 | Тухай бүр | 8 | 96 | 90 | 6 | 0 |
| 6 | Нийт | 27 | 151 | 139 | 10 | 2 |

### 3.9.2 Засгийн "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын хэрэгжилт

Байгууллагын төсвийн хөрөнгийн зарцуулалтад тогтоолын хэрэгжилтийг шалгахад дараах байдалтай байна. Үүнд:

- Тайлант онд 784,350.1 мянган төгрөгийн төсөв зарцуулахаар батлагдаж гүйцэтгэлээр 761,327.4 мянган төгрөгийг зарцуулж оны эцэст 16,147.5 мянган төгрөг буюу төсвийн 2.1 хувийг буцаан төвлөрүүлсэн.

- Албан томилолтын зардлыг 454.7 мянган төгрөгөөр баталснаас гүйцэтгэлээр 446.0 мянган төгрөг зарцуулж 8.7 мянган төгрөг хэмнэжээ.
- Байгууллагын ашиглалттай холбоотой тогтмол зардлын төсвийг анх 103,148.9 мянган төгрөгөөр, тодотголоор 101,144.0 мянган төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 94,268.9 мянган төгрөг зарцуулж анх баталсан дүнгээс 6875.1 мянган төгрөг буюу 8.6 хувь хэмнэсэн нь ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 20 хувь бууруулж хэмнэх дээрх тогтоолын 1.8 дах заалтыг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

### 3.9.3 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, тайлант хугацаанд хүнс, болон үдийн цайны зардалд худалдан авах ажиллагаа зохион байгуулсан байна.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар хууль тогтоомжийн хэрэгжилттэй өгсөн 1 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байхгүй

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 15,754.7 мянган төгрөгийн зөрчил илэрсэнд 2000.0 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 13,754.7 мянган төгрөгийн 2 зөрчилд зөвлөмж хүргүүлэв.

### 4.1. Албан шаардлага

1.1. “Хонгорын тогтвортой хөгжил” НҮТББ-ийн төслийн санхүүжилтээр туршлага судлах ажлаар Улаанбаатар хот явах замын зардал тус бүр 200.0 мянган төгрөгийг 20 багшид шилжүүлсэн боловч замын зардлын баримт бүрдүүлээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.4-д заасан "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Замын зардлын 2,000.0 мянган төгрөгийн анхан шатны баримтыг бүрдүүлж нөхөн шалгуулах баримт бүрдүүлээгүй тохиолдолд төсөвт буцаан төлүүлэх албан шаардлагыг хүргүүлэв.

**4.2 Зөвлөмж**

*1.1. Илрүүлэлт:*

Байгууллагын ашиглалттай холбоотой тогтмол зардлын төсвийг анх 103,148.9 мянган төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 94,268.9 мянган төгрөг зарцуулж Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.8[1] дахь заалтаар 20 хувь буюу 20,629.8 мянган төгрөг хэмнэхээс 6,875.1 мянган төгрөг буюу 8.6 хувь хэмнэсэн нь тогтоолыг бүрэн хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

*1.2. Өгсөн зөвлөмж:*

Цаашид Засгийн газраас төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээ болон баримтлах чиглэлийн талаар гаргасан тогтоол, журмыг хэрэгжүүлэн ажиллах.

*2.1. Илрүүлэлт:*

Шилэн дансны цахим сайтад нийт 149 мэдээ байршуулахаас 10 мэдээг хугацаа хоцроож байршуулсан нь Шилэн дансны тухай хуулийн 6.1-т заасан "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ" гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна.

*2.2. Өгсөн зөвлөмж:*

Шилэн дансны тухай хуулийн 6.1-т заасан мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулж ажиллах.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Баян-Өндөр ЕБС | 3 | 15,754.7 | 0 | 0 | 0 | 0 | 1 | 2,000.0 | 2 | 13,754.7 |

_____oOo_____

[1] байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээнд 20-иос доошгүй хувийн хэмнэлт гаргах